

ӨВӨР МОНГОЛЫН МАЛ АЖ АХУЙ БА НУТАГ БЭЛЧЭЭРИЙГ АШИГЛАХ ТУХАЙ

Профессор Насан

НЭГ. Мал аж ахуйн шинэтгэлийн ололт амжилт

Өвөр Монголын хөдөө аж ахуйн шинэтгэлийг нэгтгэн дүгнэвэл, 1983 онд Хятадын мал аж ахуйн районуудаас хамгийн түрүүнд бэлчээрийг улсын мэдэлд байлгаж, хариуцлагын систем нэвтрүүлэн, мал сүргийг үнэлэн, өрх бүрд өөрийгөө тэжээж чадах “мал , бэлчээрийг давхар хариуцах” үйлдвэрлэлийн хариуцлагын систем нэвтрүүлж, хүн, мал, бэлчээр, хариуцлага, ашгийн органик нэгдлийг хангав. Ингэснээр юуны өмнө, малчид нийтээрээ нэг адил байсан тэгшитгэлийн системийг халж, малчдын үйлдвэрлэлийн идэвхийг сэргээж, мал аж ахуйн хөгжлийн хурдацыг ахиулснаар шинэтгэл, нээлттэй бодлогоос хойш ӨМӨЗО-ы мал аж ахуйд анх удаагаа үсрэлт гарав.

Мал аж ахуйн үйлдвэрлэлд оршиж байсан олон асуудлыг шийдвэрлэхийн тулд Өвөр Монголд “мал, бэлчээрийг давхар хариуцах” системийг туршсаны үндсэн дээр, Хятадын мал аж ахуйн районуудаас анх удаа бэлчээрийг өрхөд хариуцуулах явдлыг гол болгосон “хоёр эрх нэг систем” (бэлчээр өмчлөх эрх, ашиглах эрх ба хариуцлагын систем)-ийг нэвтрүүлэв. Ингэснээр “хэрэглэх, эрхлэх, хамгаалах”, “хариуцах, эрх мэдэх, ашигтай байх” зарчмыг нэгтгэн, бэлчээрийг нийтээрээ тэгшитгэн ашиглаж байсныг халж, бэлчээрийг ашиглах, хамгаалах шинээр бий болгох, үйлдвэрлэх, хөгжүүлэх асуудлыг эмхлэн зохицуулснаар мал аж ахуй, хөгжлийн хоёрдахь шатандаа орж, хоёрдахь үсрэлт гарлаа.

“Мал бэлчээрийг давхар хариуцах систем”-ээс “хоёр эрх нэг систем”-д шилжснээр мал аж ахуйн эдийн засгийн тогтолцоонд хоёр чухал их өөрчлөлт гарлаа. Ингэснээр мал аж ахуйн өвөрмөц онцлог бүхий социализмын анхан шатны мал аж ахуйн эдийн засгийг эрхлэх систем төлөвшин бүрэлдэж, тариачид, малчдын үйлдвэрлэх, бүтээн бий болгох идэвхи сэргэж, мал аж ахуйд хоёр удаа түүхэн дэвшил гарав. Өвөр Монголын мал аж ахуйн районы эдийн засгийн шинэтгэл Хятадын бусад малжих районуудад чиглүүлэгч, үлгэр жишээч үүрэг гүйцэтгэх боллоо. Мал

*. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Зүүн хойт Ази судлалын хүрээлэнгийн орлогч захирал .

сүргийн чанар сайжирч, бэлчээр бүтээн байгуулах талаар Хятадын бүх муж, өөртөө засах орноос тэргүүн байранд орох болов. Мөн хонины ноос, нарийн ноос, ноолуур зэрэг мал аж ахуйн бүтээгдэхүүний чанараар бүх Хятадад тэргүүлж байна. Өвөр Монгол малын тоогоор бүх улсадаа эхний байранд орж, малчдын орлого Хятадын мал аж ахуйн 5 том районыхаас давж байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийн гол үзүүлэлт ба эдийн засгийн үзүүлэлтийг 1998 оныхыг 1978 оныхтой харьцуулбал ихээхэн дээшлэв. Тухайлбал:

-Малын тоо толгой их өсөв. Өвөр Монголын малын тоо 1998 онд 73 сая 872 мянгад хүрсэн нь 1978 онд 41 сая 271 мянгад хүрч 1978 онд 10 сая 348 мянга байснаасаа 4 дахин өсөв. Бүх мал сүргийн дотор үүлдэр сайжруулсан малын эзлэх хувь 1978 онд 29,1% байсан бол 1998 онд 66,6% болж, 37% өсчээ.

-Мал аж ахуйн бүтээгдэхүүний хэмжээ их өслөө. Махны нийт үйлдвэрлэл 1998 онд 1250800 тоннд хүрсэн нь 1978 онд 208900 тонн байснаасаа 6 дахин өсөв.

-Сүү үйлдвэрлэл 644 мянга тонн хүрч, 1978 онд 72,4 мянган тонн байснаасаа 8,6 дахин өсөв.

-Ноолуур 74,7 мянган тонн хүрч 1978 онд 35,5 мянган тонн байснаас 2 дахин өсөв.

-Сүргийн эргэлт мэдэгдэхүйц хурдсав. Төллөх мал 22 сая 65 мянгад хүрсэн нь 1978 онд 5 сая 936 мянга байснаас 3,7 дахин өсч төллөх хувь 36,7% хүрч 1978 оны 15,4%-иас 21%-иэр өсөв.

-Эдийн засгийн үр ашиг илтэд дээшлэв. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн өртөг 9 тэрбум 850 сая юань болж, 1978 онд 2 тэрбум 560 сая юань байснаасаа 3,8 дахин өсөв. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд эзлэх мал аж ахуйн үйлдвэрлэлийн өртөг 1978 онд 25,7% байснаа 10,3%-иар өсч 36% болов. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн өсөлт 10 тэрбум 700 сая юань болж, ӨМӨЗО-ы дотоодын нийт үйлдвэрлэлийн 1/10 хувийг эзэлж байна. Малчдын дундаж орлого 2344 юань болж тариачдын дундаж орлого 1704 юаньтай харьцуулбал 640 юаниар илүү байна. Энэ нь 1978 онд 188 юань байсантай харьцуулбал 2156 юаниар нэмэгдэж 11,5 дахин өссөн гэсэн үг.

Өвөр Монголын арьс, ноос, ноолуурын нийт хэмжээ, хөдөө аж ахуйд ажиллаж буй хүн нэг бүрд ногдох үйлдвэрлэлийн нийт хэмжээ бүх улсадаа тэргүүлж байна. Нэг хүнд ногдох мах, өндөг, сүүний хэмжээ Хятадын дундаж түвшингээс өндөр, түүний дотор мах 8,3 кг-аар илүү байна. Өвөр Монголын дотоодын зах зээл дүүрснээс гадна, жил бүр гадагш 200 мянган толгой, үхэр, хонь ба нэг сая толгой гахай нийлүүлж байна. Шинэтгэл, нээлттэй бодлого явуулсан 20 жилд Өвөр Монголоос улсад бод, бог мал 190 сая, хонины ноос 1 сая гаруй тонн, ноолуур 42 мянган тонн, үхрийн шир 9,4 сая, ямааны арьс 160 сая, сүү 4,5 сая тонныг нийлүүлсэн ба эдгээр бүтээгдэхүүний нийт өртөг 106 тэрбум юань болжээ.

Мал аж ахуйн бүтээгдэхүүн болоод боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээ ӨЗО-ы нийт экспортын 37%, түүний дотор 5 төрлийн бүтээгдэхүүний (цэвэр ноолуур, ноолууран бүтээгдэхүүн, үхрийн хөлдөөсөн мах, амьд хонь, хивс) экспортын валютын хэмжээ 10 сая америк доллараас давжээ. Мал аж ахуйн хөгжил нь Хятадын ба ӨЗО-н хөнгөн аж үйлдвэрийг хөгжүүлэх, улмаар Өвөр Монголын валютын орлогын чухал эх үүсвэр болж байна. Үүний зэрэгцээ тариачид, малчдыг ядуурлаас ангижируулж, баян чинээлэг болгох, хот хөдөөгийн иргэдийн хоол хүнсний бүтцийг сайжруулах, ард түмний амьдралын түвшинг дээшлүүлэхэд чухал хувь нэмэр оруулж байна.

Хэдэн жилийн хүчин чармайлтын үр дүнд тус ӨЗО- жил бүр 1 сая тонн мах, 60 мянган тонн ноос, 4000 тонн ноолуур, 600 мянган тонн сүү үйлдвэрлэж, малын тогтвортой өсөлт 20 саяас давлаа. Өвөр Монголын мал аж ахуйн үйлдвэрлэл байгалийн эрхшээлээс нэгэнт ангижирч ган, зудны гамшигаас шалтгаалсан тогтворгүй байдлыг халж тогтвортой хөгжиж байна. Мал аж ахуйг эрхлэх уламжлалт бүдүүлэг арга хэлбэрээс эрчимжүүлсэн, орчин үеийн арга хэлбэрт шилжиж, эдийн засгийн өсөлт өнгөрсөн үед тоо хэмжээг нэмэгдүүлэх хэлбэртэй байсан бол одоо чанар, үр ашгийг эрхэмлэх чиглэлээр өөрчлөгдөж байна.

Хоёр. Өвөр Монголд бэлчээр хамгаалж, шинээр бүй болгож ашиглаж байгаа нь

1. "Тавыг бүрдүүлсэн" өвсөн хүрээний бэлчээр бий болгох нь

Өвөр Монголд одоо 101 хошуу, сянь байгаагаас мал аж ахуй дагнасан нь 19, хагас тариалан, хагас мал аж ахуйтай хошуу, сянь 21 байна. Тэдгээрээс байгалийн гамшигт байнга өртдөг 38 хошуу, сянийг Хятадын ХААЯ ба Сангийн Яам байгалийн гамшигтай тэмцэх бааз газар болгохоор хөрөнгө оруулалт хийв. Эдгээр нутагт ус, өвс, ой мод, машин техник, түүхий эд бүхий "таван цогц" том, дунд, бага хэмжээний өвсөн хүрээ байгуулж, гантай, гамшигтай ч ургацаа алдамгүй, өндөр тогтвортой ажиллах тэжээлийн бааз байгуулж, стандартын дулаан хашаа, дулаан хороог олноор байгуулав. Мал аж ахуйг байгалийн бэрхшээлээс урьдчилан хамгаалахад их хүч тавихын зэрэгцээ бүтээн байгуулалтын хэмжээ хэлбэрийг зохицуулах, өрхийн болон бага оворынхыг гол болгож, усгүй, ус дутагдалтай бэлчээрт бага оврын өвсөн хүрээ байгуулж, "тариалалтыг малжих оронд нэвтрүүлж", үрээ сайн бэлтгэж, арвин ургац, өндөр үр ашгийн төлөө ажилласан юм. Нэг малд нэг му (1 му = 0,15 га) газар

оногдохоор байнгын хадлангийн талбай, усалгаатай талбай, баталгаатай малын тэжээл бэлтгэх хэрэгтэй.

Дээр дурдсан бэлчээр бий болгох арга хэмжээ нь мал аж ахуйн хөгжилд идэвхитэй үүрэг гүйцэтгэнэ. Өвөр Монголын малын тоо 40 саяас 50 саяд хүрэхэд 25 жилийн хугацаа шаардсан бол 50 саяас 60 сая болоход ердөө 6 жил шаардагдсан юм. Үүний дотор мал аж ахуйг байгалийн гамшигаас хамгаалах бааз суурь бий болгосон нь юугаар ч орлуулшгүй чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Мал аж ахуйг байгалийн гамшигаас хамгаалах бааз суурь байгуулсан 12 жил (1985-1997) бол Өвөр Монголын мал аж ахуй тасралтгүй сайн хөгжсөн 12 жил юм. Одоо энэ загвар Хятадын мал аж ахуйн районуудын бэлчээр ашиглах, бий болгох гол хэлбэр болоод байна. Өвөр Монголчууд энэ хэлбэрийг хүнээр зүйрлэвэл мал сүргээ “өмсөх хувцастай идэх хоолтой” болголоо гэж ярьдаг юм. Улсаас гамшигтай тэмцэх бааз байгуулах зорилтыг тал нутгийн мал аж ахуйн үлгэр жишээ зорилт болгож, энэ ажлыг үргэлжлүүлэн өргөтгөж, хөрөнгө оруулалт хийж байна. Ингэхдээ хувьчилсан малын бэлчээр, хувийн аж ахуйтан, шинжлэх ухаан, техникийн үлгэр жишээ өрх, тариалан мал аж ахуйг хослон эрхэлсэн өрхүүдийг юуны өмнө анхаарав. Одоо бүтээн байгуулалтын хүрээ хэмжээ байнга өргөжиж, жижиг өвсөн хүрээнээс том өвсөн хүрээ байгуулах, тогтмол суурин газраас бүхэлд нь даан хариуцсан бэлчээр эзэмших үйл явц тасралтгүй өрнөж байна. Тоо бүртгэлийн мэдээгээр, гамшигтай тэмцэх бааз газрын өндөр тогтвортой ургацтай, хадлангийн талбай 33 сая 245 мянган му (4986750 га) байгаа нь мал тутамд 1,1 му (0,165 га) газар ногдоно гэсэн үг юм. Жилд 5 сая 140 мянган тонн хадлан бэлтгэж өвлийг давах фондын өвс 170 кг-ийг нөөцөлж байна. Тэжээл бэлтгэх талбай 5,6 сая му (840 мянган га) түүний дотор усалгаатай талбай 1,6 сая му, (240 мянган га) буюу нэг малд 0,19 му тэжээлийн талбай, 0,05 му усалгаатай талбай ногдож байна. Ногоон тэжээл 890 сая тонн, боловсруулсан тэжээл 1 сая 405 мянган тонн бэлтгэж байна. Хашаа хороо барих ажил 95%, хүрч түүний дотор дулаан хашаа 11,7%-ийг эзэлж байна. Өвөр Монголын 420 мянган малчин өрхөөс 175 мянган өрх байгалийн гамшигаас урьдчилан сэргийлэх бааз суурьтай болов.

БНХАУ байгуулагдахаас өмнө Өвөр Монголын мал сүрэг, бэлчээр цөөн хэдэн баячуудын гарт төвлөрч, ихэнхи малчид отор хийж, өвс ус даган нүүдэллэж, сонгодог нүүдлийн хэв маягтай амьдарч байв. БНХАУ байгуулагдсаны дараахи эхний хэдэн жилд мал хөрөнгийг хуваахгүй тэмцэлдэхгүй, анги ялгаварлахгүй болоод ядуу, баян малчин харилцан ашигтай ажиллах “гурван үгүй, хоёр ашигтай” байх, “хүн, мал хоёр дэгжирэх” худалдан авч, малчлалын талбай байгуулах, нэгдэлжих хөдөгөөн өрнүүлэв. Бэлчээр, малыг нийтийн болгож, хот айлаараа нэгж болон мал сүргээ хариуцан “сүргийн систем” бий болгож, отор нүүдэл хийж байв. Сум бүхий газрыг гол болгож тариачны тосгон хэлбэрийн нэгдэл, суурин

газар, бага сургууль, эмнэлэг, мал эмнэлгийн станц, ханган борлуулах хоршоо байгуулав. ХКН-ын XI дэх удаагийн III бүгд хурлаас хойш малжих районд социалист онцлогтой мал аж ахуй эрхэлж, газар сайгүй “мал, бэлчээрийг давхар хариуцах” ажил өрнөж, малыг хувь хүн, өрхөд үнэлэн өгөв.

Улсаас бэлчээр эрхлэх төлбөр авч, малын тоогоор татвар хураах болов. Ингээд малчид өөрсдийн бэлчээрт суурьшиж, байшин барьж, хашаа саравч, өвсөн хүрээ байгуулж, хөнгөн маягийн торон хашаагаар хүрээлэх боллоо. Гэхдээ 70-иад оны үе шиг чулуун хана хэрэм босгож, өвсөн хүрээ байгуулахаа болив. Ингэж олон жил “нүүдлийн мал аж ахуйг суурьшуулах” гэсэн уриа сая амьдралд биелэлээ олов.

Энэ үндсэн дээр хоёрдахь буюу бэлчээр хариуцахыг гол болгосон “хоёр эрх, нэг систем” (бэлчээр өмчлөх эрх, ашиглах эрх ба хариуцлагын систем)-ийн шинэтгэл хийж малчдын бэлчээрээ ашиглах идэвхийг улам сэргээв. Одоо малчид өвөл хавар суурин сууж, зун, намар отор хийн нүүж байна. Малчдын хүүхэд гацаа, сумын бага сургуульд сурч, хошуунд 9 жилийн дунд сургуульд, аймагт 12 жилийн дунд сургуульд суралцаж байна.

Өвөр Монголын малжих районы гацаа, сум бүгд цахилгаантай, ихэнхи суурин газарт салхины цахилгаан үүсгүүр байрлуулснаар малчид гэртээ суугаад зурагт үзэх болжээ. Бэлчээр, малаа давхар хариуцсан 20 жилд малжих районууд бүдүүлэг хөгжлөөс эрчимжсэн хөгжлийн замд орж, баян малчид төрж гарлаа. Зүүн Үзэмчин хошууны Эрээн говь сумын Эрээнбулаг гацааны 42 настай Бадамсүрэн жилдээ 1600 толгой төл бойжуулж, 4200 толгой малтай баян айл болжээ. Тэрээр 1995 оны 1-р сард 6 малчинтай хамтран хувийн зардлаараа Австралид жуулчилж, мал аж ахуй эрхлэх орчин үеийн арга, тэргүүн туршлагаас суралцсан байна. Бадамсүрэнгийнх одоо 600 мянган юаны үл хөдлөх хөрөнгөтэй, жилдээ 200 мянган юаны орлоготой, 15 мянган му (2250 га) өвсөн хүрээтэй, 17 тасалгаатай дулаан хашаа пүнз, том, бага трактор, өвс хадах машин зэрэг мал аж ахуйд хэрэглэх иж бүрэн техник төхөөрөмжтэй, томоохон, эрчимжсэн аж ахуй эрхэлсэн баян айл болжээ.

2. Элсэн говь бэлчээр болон хувирч байна

Өвөр Монголд мод суулгаж, өвс ургамал тариалахыг гол болгож “урьдчилан сэргийлэх, засаж тордох, иж бүрэн тордож сайжруулах”, “хэн эвдэж, бохирдуулна, тэр засаж сайжруулна” гэсэн бэлчээр хамгаалах, бүтээн байгуулах бодлого явуулснаар зөвхөн VIII 5 жилийн хугацаанд 1 тэрбум 263 сая юаны хөрөнгө оруулалт хийв. Арван хэдэн жилийн чармайлтаар “гурван умарт” буюу Синьзян, Ганьсу, Өвөр Монголд элснээс хамгаалах ойн зурвас байгуулж, жил бүр 316 мянган га газарт мод суулгаж байна. Өвөр Монголын ногоон байгууламж жил бүр 5 сая му (750 мянган га) талбайгаар нэмэгдэж байна. Жилд тарьж буй мод, хүн бүрд

ноогдох ойн талбай зэрэг 10 үзүүлэлтээр Бүх Хятадад Өвөр Монгол 1-р байранд ордог юм. “Гурван умарт”-ыг хамгаалах ойн зурвасны хоёрдахь байгууламжийг хугацаанаас нь хоёр жилийн өмнө дуусгаж цөлжилөөс урьдчилан сэргийлэх, цөлжилтэй тэмцэх ажлаар бүх улсдаа тэргүүн эгнээнд орлоо. Одоо ӨЗО-ы сайжруулсан бэлчээр, торлож хашаалсан бэлчээр, хиймэл бэлчээр 100 сая гаруй му (15 сая га) болов. ӨЗО-ы ойн талбай 14,2% хүрч 1989 оныхоос 0,7% нэмэгдэв. Өвөр Монголын экологи-хөдөө аж ахуйн туршилтын сум, сянъ 19, экологийн туршилтын гацаа 200 болж, туршилтын талбай 7,18 км² болов.

Сүүлийн хэдэн жилд элсний нүүдэл Бээжинд ойртож, цагаан хэрмийг ч, Япон тэнгисийг ч өнгөрлөө. “Элсэн говь Бээжингээс ердөө л 70 км зайтай байна” гэсэн мэдээ Бээжингийн олон сонины тэргүүн нүүрний эхэнд гарсан юм. Ард иргэдийн цөлжилөөс хамгаалах, сэргийлэх мэдлэг урьд өмнө байгаагүйгээр дээшиллээ. Эзэнэ хошууныхан тоорой, жигд, заг, сухай голлон тарьсан бэлчээр бий болгож байна. Гэвч 300 жилийн настай тооройн ой жил бүр 50-70 мянган му (7500-10500 га) талбайгаар багасаж, Эзэнэгийн ногоон бүснээс ердөө л 5 сая му (750 мянга гаруй га) газар үлдлээ. Ногоон бүрд элсэн цөл болов. Үүнийг хүмүүс цөлжихийн шалтгаан гэж үзэж байна.

Бээжин хот, Шар мөрнийг элснээс хамгаалахын тулд 15 мянган хүн амтай Эзэнэчүүд “Бид хэдийгээр элсэн говийг ногоон бүс болгох хүчин чадал мөхөс ч ногоон бүсийг элсэн цөл болгохоос сэргийлж чадна” гэсэн итгэл зоригтойгоор жил бүр 800-1000 му газар (120-150 га) мод, бут өвс ургамал тариалж байна. Тэд ус ховор говь газарт ногоон бүс байгуулж “нарийн голын ойн бүс”-ийг 13 км² газарт байгуулжээ. Тэд цаг агаарыг өөрчилж, салхийг багасгаж, Эзэнэ хошууны төв-Далай хөв балгасанд элсний нүүдэл нэвтрэхээс сэргийлж, тухайн газрын нийгмийн хөгжлийг хангах экологийн хаалт бий болгохыг зорьж байна. Малчин бүр мод суулгаж тарьснаа ой хамгаалах ангид мэдэгддэг. Хүмүүс чихэр өвс зэргийг түүж худалддаг байсныг одоо хориглон зогсоожээ.

Алаша аймаг 270 мянган км² газар нутагтай. Түүний дотор 91 мянган км² нь говь, 84 мянган км² нь элсэн цөл болоод уул, толгод, 30-40 мянган км² нь ойн ногоон бүс юм. Хүн, материалын хүчээр хүрээлэн буй орчныг дахин сүйдэхээс хамгаалж болно. Алаша аймгийн Тэнгэр элсэн цөл Шар мөрөнд нөлөөлж буй хэсэг нь 260 км юм. Иймээс Алаша аймаг хүрээлэн буй орчныг засаж сайжруулахад ихээхэн анхаарч байна.

Алашагийнханы зорилт бол жил бүр 1000 км² газарт нөхөн ургалт хийх, 2010 он гэхэд ногоон бүс бий болгох, 2050 онд хүрээлэн буй орчныг эрс өөрчлөн сайжруулах явдал юм.

Японы 93 настай өндөр настан, цөлжил судлаач Тояама Масахидо 1979 онд Хятадын баруун хязгаарыг судлах ангитай хамт Бээжингээс гарч, торгоны зам даган явж Хятадын баруун хэсгийн говьд очжээ. Тэр үеэс энэ өндөр настанд Шар мөрний сав газрыг ногооруулж, Хятад, Японы үе

үеийн найрамдлын цэцгийг дэлгэрүүлэх юмсан гэсэн нэгэн шинэ хүсэл төржээ. Тэр цагаас хойш Масахидо гуай 6 хавар, намар Япон, Хятадын хооронд явж, жил бүр Хятадад 4 сараас дээш хугацаагаар ажиллах болов. Японы ард түмэн удаа дараа Хятадын элс манханыг нээн ашиглах ажилд хөрөнгө оруулж, хэдэнтээ буцалтгүй тусламж үзүүлэн, Синьзян, Нинся, Ганьсугийн элсэн говийг засч сэргээх ажил хийв. Нинсягийн Жунбэй сяний элсэн толгод дээр усан үзмийн цэцэрлэгт 3 удаа арвин их жимс багсайн ургаж, Шар мөрний хөвөөгөөр маалингын үр үндэслэж, жилийн жилд цэцэглэн дэлгэрэх боллоо.

Муу-Усны говьд шинээр суулгасан 120 мянган улиас мод элсэн говьд урган цэцэглэлээ. Тояама Масахидо 1991 оны 7-р сард Хятадын говийг ногооруулах анхдагч ажлын ангийг тэргүүлж, Их Зуу аймгийн Хөвчийн элсэн манханы Энхбай гэдэг газар хүрчээ. Тэгэхдээ Япон дахь гэрийн эд хөрөнгөө худалдаж Энхбайд хөрөнгө оруулж, тэндэхийн мод тарих ангийн “цалингүй дарга” болов. Энэ үеэс тэрээр жил бүр Энхбайд 200 гаруй өдөр ажиллах болжээ. Өндөр настан япон хүний хүсэл гэвэл энэ газар НҮБ-ийн элс манханыг нээн ашиглах их сургууль байгуулах, бас Энхбайг нээн ашигласны 10 жилийн ойгоор энд цөлжилтийн асуудлаар дэлхийн хурал хийх явдал юм. Одоо Энхбай 21 мянган му (3150 га) бэлчээр, 60 мянган му (9000га) таримал өвсний талбай, 1,6 сая ширхэг мод, 200 му (30 га) жимсний цэцэрлэг, 8 сая куб.м багтаамжтай 2 усан сантай болоод байна.Тояама Масахидо “Энхбай бол миний хамгийн сүүлчийн амьдралаа зориулсан газар юм. Энхбай бол миний амьдралын төгсгөл болно” гэж хэлсэн байдаг.

Өвөр Монголын Ойн дээд сургуулийн профессор Найманхүү (Най Минфу) олон жил багшлах, судлах ажил хийж, “Найман хошууны нийлмэл экологийн эдийн засгийн системийг задлан шинжилсэн хийгээд зохицуулан эзэмших нь” гэсэн сэдвийг удирдан ажиллаж, Улсын ядуу хошууны нэг Найман хошууны үйлдвэрлэлийн бүтэц, газар ашиглалт, ургамлын бүтэц, мал сүргийн бүтэц зэрэг 23 төрлийн бүтцийг сайжруулан засчээ. 1991 он гэхэд уг хошуунд нийт 16818 ядуу өрх байсны 10814 өрх нь одоо идэх хоол, өмсөх хувцастай болсон байна. Мөн хүн бүрд 1341 юаны орлого ногдож байна. Тэрээр энэ ажлынхаа үндсэн дээр “бэлчээр цөлжихийг хязгаарлахад хэрэглэх судалгаа ба Хорчины элст нутгийг системтэйгээр нээж ашиглах” гэсэн сэдвийг удирдаж байна. Одоо дээрх хоёр сэдвийн үр дүнг Өвөр Монголын 7 аймаг, 3 хот, 15 хошуу, 31 сум (гацаа)-анд өргөн нэвтрүүлж (1990-1996 онд) 4,3 тэрбум юаны эдийн засгийн ашиг олжээ.

3.Бэлчээрийг хамгаалах талаархи чиглэл, бодлого, арга хэмжээ ба тэмцлийн зорилго

ХКН-ын Төв Хорооны XI удаагийн III бүгд хурлаас хойш, хүрээлэн буй орчныг хамгаалах явдлыг чухалчилан анхаарч, тал нутгийг хамгаалах элсний нүүдлээс сэргийлэх асуудал олны анхаарлын төвд оров. “БНХАУ-ын нутаг бэлчээрийн хууль”, “ӨМӨЗО-ы нутаг бэлчээрийг эрхлэх дүрэм”, “ӨМӨЗО-ы үндсэн бэлчээр хамгаалах дүрэм”, “ӨМӨЗО-ы нутаг бэлчээрийг эрхлэх ажлыг хэрэгжүүлэх нарийвчилсан журам”, “ӨМӨЗО-ы тариалан, мал аж ахуйн хариуцлагын гэрээний дүрэм” зэрэг хууль тогтоомжийг удаа дараалан гаргаж, нутаг бэлчээрийг хамгаалах, эрхлэх, ашиглах явдлын эрх зүйн үндсийг тавьж нутаг бэлчээрийн хууль эрхийн системийг анхлаж сайжруулж, нутаг бэлчээрийг хамгаалах эрхлэхэд хуулийг баримталж, чанга сахих болов.

Нутаг бэлчээрийг хамгаалах, эрхлэх зүй зохистой ашиглах хийгээд цөлжилөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх талаар нэлээд амжилт олж, зарим туршлага хуримтлуулсан хэдий ч одоо манай ӨЗО-ыг нийтэд нь авч хэлбэл, нутаг бэлчээрийн экологи үргэлжилэн муудах байдал үндсээрээ өөрчлөгдөөгүй, мал ихдэж, бэлчээр хомсдоноос үүсэл зөрчил улам бүр их гарч, бэлчээрийн мал аж ахуйн хөгжилд ноцтой саад болж байна. Иймээс бэлчээр хамгаалах, бэлчээр бий болгох ажлыг цаашид чангатгахын тулд ӨЗО-ын намын хороо, Засгийн газар 1999 онд нэлээд бодлогын арга хэмжээ авч, бэлчээр хамгаалах, бэлчээр бий болгох удирдамжийн чиглэл, зорилтыг тодорхойлон гаргалаа. Тодорхой хэлбэл, бодлогын чанартай гол арга хэмжээ нь дараахи 11 зүйл болно. Үүнд:

1.Бэлчээр сүйтгэхийг хориглох. Аливаа байгууллага, хувь хүн нутаг бэлчээрийг хагалах, ургамал түүх, огтлох, ухах, ан агналтын хуулийг баримтлаж, зөвшөөрөл авч, хянан шалгуулж, тогтсон журмын дагуу ажиллах, тогтоосон бэлчээрийн татварыг төлөх ёстой. Их хэмжээгээр, бүлэглэн дураар ихээр тасдах, ухах тал нутгийн байдлыг эвдэхийг холбогдох орон нутгийн Засгийн газар бүх талын хүчнийг зохион байгуулж тусгайлан засаж залруулах хэрэгтэй.Иймээс илүү ихээр атар хагалах, газар ухах, ан агнах нь ноцтой уршиг тарих учраас хуулиа баримталж шийтгэх хэрэгтэй.

2.Тогтоосоныг зөрчих атар хагалбал сайтар шалгаж, хуулийн дагуу хагалагчийг ба зөвшөөрсөн хариуцлагатанд арга хэмжээ авч, заасан хугацаанд ургамлын бүрхэвчийг сэргээх, буюу сэргээхэд шаардагдах мөнгийг гаргуулж бэлчээр хариуцсан байгууллагаар бэлчээрийг нөхөн сэргээлгэнэ.Иймээс газар нутгийг ашиглахдаа төлөвлөгөөтэйгээр атар хагалах хэрэгтэй. Хошуу, сяниар мал аж ахуй эрхлэх холбогдох байгууллага зөвшөөрөл авах тогтоож өгсөн газар, ой усжуулалт зэрэг баталгаатай арга хэмжээг авсны дараа газар эрхлэх байгууллага шалгаж, дахин ӨЗО-ы

ардын засгийн газарт мэдүүлж батлуулсан байх, атар хагалсны дараа 2 жилийн дараа хуучин тогтоосон ой мод, худаг ус ашиглах нөхцөлийг шууд хааж, заасан хугацаанд ургамлын бүрхэвчийг сэргээх хэрэгтэй. Тариачин, малчид ба хариуцлагын системийг эрхлэх байгууллага мод, тэжээл, өвс тарих, атар хагалахаар хариуцсан нутгийг хошуу, сяны Ардын Засгийн газраас тогтоосон төлөвлөгөө, тогтоож өгсөн атар хагалах хэмжээ ба нийт хошууны атар хагалах хэмжээг шалган тогтоож өгөх хэрэгтэй. Тогтоосон газрыг ба ойг хамгаалах арга хэмжээг тодорхойлж, ӨЗО-ы Ардын Засгийн газраас батална. Улмаар эдгээр арга хэмжээний явцад салхины элэгдэл, элсжих ба газрын хөрс усанд идэгдэхээс урьдчилан сэргийлнэ. Өвстэй газрыг бий болгох нэрээр, мал бэлчээрийг хагалж, ургамал, үр тариа тарих буюу нэг наст ургамал тарихыг хатуу хориглоно. Атаржсан бэл газар, салхинд идэгдэж элсжсэн газрыг дахин хагалж болохгүй. Тэгвэл бэлчээрийг шинээр хагалсантай адил шийтгэнэ.

3. Бэлчээрийн хувиралтыг шалгах ажлыг чангатгах.

ӨЗО-ы мал аж ахуйг голлон эрхлэх байгууллагууд бүх районы бэлчээрийг хянан шалгах систем бий болгож, бэлчээрийн тоо хэмжээ, чанар, өвс тэжээлийн үйлдвэрлэлийн хэмжээний хувиралын байдал ба бэлчээрийг сүйтгэж буй олон төрлийн хүчин зүйлийг сайтар анхаарч байх хэрэгтэй.

4. Малжих район, хагас тариалан, хагас малжих район олон наст тэжээлийн ургамал тариалах ба услалттай өвсөн хүрээ байгуулахыг гол болгож, бүх төрлийн арга хэлбэрээр бэлчээр бий болгох, усны эх булгийг нээж ашиглах, түүнийг арвилан хэмнэх бэлчээрийн үр ашигтай усжуулсан талбайг өргөтгөх хэрэгтэй. Тариалах орон, ойн орон ба хот газар ургамлын бүтцийг тохируулж, өвс ургамал тариалалтыг хөгжүүлж өвсөн талбайг өргөтгөх хэрэгтэй.

Налуу энгэр газрын тариалан талбайд налуу хэлбэрийн шаталсан талбай буюу услалттай, хамгаалахын зурвастай газраас гадна 25 градусаас илүү налуу газар дахь хагалсан газар, ой, өвс бэлчээрийг төлөвлөгөөтэй, дэс дараатай, аажмаар атаршуулах хэрэгтэй. Үүний зэрэгцээ 25 градусаас доош налуу энгэр газрыг тариан талбайд “энгэр газрыг шатлах” өндөр, тогтвортой үйлдвэрлэл бүхий шаталсан талбай байгуулах хэрэгтэй. 40 градусаас илүү налуу газар, бэлчээрт өвс ургамал нахиалах цагаар мал бэлчээхийг хориглох, бусад улиралд төлөвлөгөөтэйгээр мал бэлчээнэ.

5. Хужиртай, элстэй, атаржсан бэлчээрийг засан сэргээх ажлыг түргэтгэх. Онгон уул, онгон газар элс манхан, хужиртай бэлчээрийг хариуцан авч засаж сэргээх хэрэгтэй. Хариуцах хүнгүй их цөлжсөн, атаржсан бэлчээрийн хувьцаагаар хамтрах, тендер зарлах, дуудлага худалдаанд оруулах зэрэг хэлбэрээр төвлөрүүлэн засах, хэн засна тэр хөрөнгө оруулна. Тэр ашгаа олно гэсэн зарчмыг баримтлана.

6. Өвс ургамлын үрийн бэлтгэл хийх сайн чанарын өвс ургамлын үрийг гаднаас оруулж, ургуулах, олон газар дэлгэрүүлэх, үрийн талбай,

өргөтгөсөн талбай, олон хүн ажилладаг үйлдвэрлэлийн газрыг гол болгон, өвс ургамлын үрийг тариалах систем бий болгох хэрэгтэй. Үрийг шалгах ажлыг чангатгах, өвчнийг шалгах, үйлдвэрлэл явуулах лиценз авах, хууль бус үйлдвэрлэлийг хориглох явдлыг чангатгана.

Чанар муутай үрээр тариалалт хийвэл аливаа хохирлыг уг тариалгагчаар төлүүлэх ба хуулийн дагуу шийтгэл ноогдуулна.

7.Бэлчээрийн шинжлэх ухаан техникийн ажлыг сайжруулах. Сайн чанарын үр бэлтгэх, үрийг хольж тариалах, үрийг савлах, ус хэмнэх, бордох, онгоцоор үр цацах, хиймэл бороо оруулах, алсын зайнаас шалгах зэрэг олон төрлийн тохирох техник технологийг өргөнөөр нэвтрүүлж, шинэ технологийг идэвхитэй ашиглах, өвс тариалах ажлын шинжлэх ухаан техникийн багтаамжийг нэмэгдүүлэх, холбогдох асуудлаар ба шинжлэх ухаан техникийн төвөгтэй асуудлыг шинжлэх ухаан ба сургалтын байгууллага зохион байгуулж, үйлдвэрлэлийн үр дүнг дээшлүүлэх хэрэгтэй. Бүх сум гацаад балгасны өвс ургамал тариалах ажлыг уялдуулах тусгай үйлчилгээний байгууллага тариачин, малчид өөрсдөө үйлчлэх байгууллага байгуулж, шинжлэх ухаан техникийн ажилтныг үйлдвэрлэлийн эхний шугамд очиж өвс ургамал тариалах технологийг хариуцах болон техник технологийг өргөн нэвтрүүлэхийг урамшуулах хэрэгтэй. Тариачид, малчдад өвс ургамал тариалах технологийг сургах ажлыг сайжруулах, бэлчээрийн экологийн мэдлэг, шинжлэх ухаан техникийн соёлыг чармайн дээшлүүлэх хэрэгтэй.

8.Бэлчээрийн экологийг хамгаалах.Бүх шатны ардын засгийн газар бэлчээрийн экологийг хамгаалах төлөвлөгөө хийж бэлчээрийг хамгаалах ой, салхинаас хамгаалж суулгасан ой болон хот балгас, суурин газрыг хамгаалах ойг бий болгох, био-эдийн засгийн хүрээ бий болгох бэлчээрийн ой бүрхэвчийн талбайг нэмэгдүүлэх, цөлжин буй бэлчээрт мал бэлчээхийг хориглож ургамлын бүрхүүлийг нь нэмэгдүүлэх хэрэгтэй.

9.Бэлчээр бий болгох ажлыг урамшуулах бодлого.Малчид зөвшөөрөл авсны дараа усалгаатай өвсөн хүрээний дотор хэрэглээний тэжээлийн өвсөө тарьж болох ба тариан татвараас чөлөөлөгдөнө.Ихээр атаршсан бэлчээр ба элстэй газар, уулархаг газрын бэлчээрийг экологийн орчин бүрдүүлэх, бэлчээрийн ургамлын бүрхэвчийг сэргээх, шинээр бий болж буй таримал ургамлын аж ахуйн орлого зэрэгт “элстэй, уулархаг районы экологийн орчинг сайжруулах тухай шийдвэрийг” үндэслэн хөнгөлөлт үзүүлнэ.

10.Бэлчээрийг бүтээн байгуулах үйлчилгээний газрыг дэмжих.

Бэлчээрийн технологийг нэвтрүүлэх ба эрхлэх байгууллагууд нь стандартын үр сонгох, үлгэр жишээчээр өвс ургамал тариалах шинжлэх ухаан техникийн ажилтнууд бэлчээрийн технологийг хариуцснаас орох орлого шинжлэх ухааны үйлс ба тариалан мал аж ахуйг дэмжсэн хөнгөлөлтэй бодлого явуулна.

11.Идэвхтэйгээр мөнгө олж, бэлчээр бий болгох, түүнийг хамгаалахад мөнгө зарцуулахыг хүчтэй болгоно. ӨЗО-ы бүх шатны төлөвлөлт ба санхүүгийн байгууллага бэлчээрийн экологи ба бэлчээр бий болгоход мөнгө хөрөнгөний хөнгөлөлт үзүүлнэ. Бэлчээр бий болгоход хэрэглэгдэх хөрөнгө санхүүгийн хүчин чадал нэмэгдвэл бэлчээр төдий чинээ нэмэгдүүлнэ.

Санхүүгийн байгууллагынхан бэлчээр хамгаалах ба бий болгох ажлыг хөдөө аж ахуйн тусгай зээллэг олгоход голлон дэмжинэ.

Нээлттэй бодлогыг өргөтгөж, хөрөнгө мөнгийг татан оруулж, малчдын хөрөнгө оруулалтыг гол болгон, улсын хөрөнгө оруулалтыг удирдамж болгосон олон сувгийг олон давхаргат хөрөнгө оруулалтыг төлөвшүүлнэ.

Бэлчээрийн хамгаалалт, бүтээн байгуулалтын ажлын түвшинг ахиулахын тулд ӨЗО-ы намын хороо, Засгийн газраас “бүх талаар төлөвлөсөн, хуулиа барьж удирдах, зохистой ашиглах, бүтээн байгуулалтыг түргэтгэх, усны эх булгийг нээж ашиглах, тэжээл үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх бэлчээрийн экологийн тэнцвэрийг хадгалах” тухай удирдамж чиглэл гаргасан.

Мөн одоогоос эхлэн 2030 он хүртэл бэлчээр хамгаалах, бий болгох ажлын зорилтыг тодорхойлов. Үүнд:

1999-2000 онд жил бүр 30 сая му-гаас (4,5 сая га) дээш бэлчээр бий болгох түүний дотор олон наст ургамлын бэлчээр 5 сая му (750 мянган га) сайжруулсан хадлангийн талбайг 10, сая му (1,5 сая га)-д хүргэж бэлчээр, малын зөрчлийг шийдвэрлэнэ.

2000-2010 онд, бэлчээр нутгийн нийт хэмжээг жил бүр 35,000 сая му-д хүргэж (5,25 сая га) нутаг бэлчээр цөлжих, атарших хандлагыг хязгаарлах ба ноцтой ихээр атаршсан газрыг эхний алхамд сэргээн засна. Бүх районы хошуу, сяний 70% нь малд дундажаар 1 му өвсөн талбай буюу усалгаат тэжээлийн газар ногдож, үндсэндээ мал, бэлчээр тэнцвэртэй байна.

2011-2030 онд бэлчээр бий болгох хэмжээг жил бүр 50 сая (7,5 сая га) му-д хүргэж, цөлжсөн, атаршсан газрыг үр бүтэмжтэй засаж сайжруулан, ихэнхи хэсгийг бэлчээрт ашиглах ба мал, бэлчээрийн зохистой харьцаа бүхий бэлчээр хамгаалах, бий болгох ойр, дунд урт хугацааны зорилтыг хэрэгжүүлнэ. Бид ӨЗО-ы намын хороо, Засгийн газрын зөв удирдлагаар дээр дурьдсан зорилгоо заавал хэрэгжүүлж чадна гэж найдаж байна.

Аливаа улсын нөхцөл байдал өөр өөр. Манай ӨМӨЗО-ы бэлчээр хамгаалах, бий болгох улс төрийн бодлого, арга хэмжээ бол Хятад улс ӨМӨЗО-ы бодит байдалд тулгуурлан хэрэгжиж байна.

Иймээс бусад улсын тухайд гэвэл бидний арга зүй заавал бүрэн таарч нийцэхгүй, зөвхөн харгалзан үзэж болох юм.

Хятад хэлнээс орчуулсан

Л.Бэгзжав